

ГЭР БҮЛ ДЭХ ОЮУНЫ БА ХАРИЛЦААНЫ СОЁЛД  
ТЕЛЕВИЗИЙН ГҮЙЦЭТГЭЖ БУЙ ҮҮРЭГ

Х.Энхтуяа\*

\* "Отгонтэнгэр" их сургууль, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, докторант

**Түлхүүр үг:** гэр бүл, боловсрол, соёл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, үүрэг, харилцаа, телевизийн нэвтрүүлэг, мэдээ мэдээлэл, хүүхдийн хүмүүжил.

**Х**үний хөгжил нийгэм төлөвших анхдагч микро орчин нь гэр бүл юм. Тиймээс Америкийн сурган хүмүүжүүлэгч Адлер Феликс "Гэр бүл бол бичил нийгэм юм. Түүний бүрэн бүтэн байдлаас нийгмийн амгалан тайван шалтгаалдаг" гэжээ. Тэрээр гэр бүл болоод нийгмийн холбоо харилцааг товч бөгөөд тодорхой дүгнэн хэлсэн байна.

Тэгвэл гэр бүл тогтвортой байхын гол шалгуур нь юу болж таарах вэ? Энэ бол яах аргагүй боловсрол, соёлын төвшин. Боловсрол хэмээх ухагдахууныг "тухайн насны суралцагсдад төлөвшсөн тулгуур мэдлэг хүмүүнлэг харилцаа, амьдрах ерөнхий арга чадварын цогц" гэж Л.Ф.Колесников тодорхойлжээ. Тэгэхээр энэ бүхнийг бүрэн агуулж буй бие

хүн буюу гэр бүл нь тогтвортой боловсролгүй болж, улмаар тэдний хоорондын харьцаа зөрчил саадгүй байна гэсэн үг. Боловсролын төвшин гэх ойлголт нь аливааг ялгаж салгах чадвар бүхий байж өөрийн оюундаа тусгаж авах үйлдэл гэж хэлж болно. Энэ нь хүний сонирхол хэрэгцээнд тулгуурласан ухамсраар нь дамжуулан идэвхиждэг үйлдэл юм. Хүний үйл ажиллагааг идэвхижүүлэх эх булаг болох хэрэгцээнээс үүдэн гарах шаардлагаас харилцаа бий болдог байна. Хүн нийгэмтэйгээ харилцан холбоонд оршиж байдаг. Тэрхүү харилцааны нэг хэлбэр нь мэдээлэл солилцоо юм. Мэдээлэл солилцоонд орж буй субъектийн тусгаж авах чадварын хэмжээгээр амьдралын төвшин тодорхойлогдоно.

Хүмүүс мэдээллийн солилцоондоо зайлшгүй шаардагдах ОНМХ-ийг ашигладаг. Нэг ёсондоо хүмүүс ОНМХ-ээр дамжин бие биетэйгээ мэдээллийн харилцаанд орж байна гэсэн үг. Гэр

бүлийн гишүүдийн үйл ажиллагаа, хоорондын харилцаа нь соёлтой салшгүй холбоотой. Соёл гэдэг бол хүнийг бүх талаар нь хөгжүүлж, төлөвшүүлж байдаг идэвхтэй, бүтээлч шинж чанарыг агуулсан нийгмийн онцгой үзэгдэл.

Соёл нь олон түмний мэдээллийн чухал хэрэгсэл болох телевизээр дамжин гэр бүл, хувь хүнд хүрдэг. Гэвч бид гэр бүл дэх оюуны болон харилцааны соёлд амьдралын түвшин, эцэг эхийн боловсрол, хүрээлэн буй орчиноос гадна бидний өдөр тутам цаг гаргаж, сонирхон хандаж байдаг телевизийн үүрэг ямар чухал болохыг анзаардаггүй байж болох юм. Бидний амьдралд, айл гэр болгонд тэр тусмаа гэр бүлийн соёлд телевизийн гүйцэтгэж буй үүрэг асар их.

**Г**эр бүл бол нийгмийн үндэс бөгөөд соёлын томоохон орчин мөн. Гэр бүлийг үр хүүхэдгүйгээр төсөөлөх боломжгүй. Гэр бүлийн орчин эцэг эх, хүүхдийн хоорондох харилцаа ямар байхаас шалтгаалж хүүхдийн сэтгэхүй, хүмүүжил соёлд ихээхэн нөлөөлдөг. Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжийн хүрээнд эрүүл саруул өсөж торних ёстой. Гэр бүлийн соёл нь орчин тойрондоо нөлөөлж бусдад, нийгэмд хүрч түгдэг. Гэр бүл бол соёл, харилцааны анхдагч томоохон сургууль бөгөөд хүүхэд мэндэлсэн цагаасаа эхлэн гэр бүлийнхээ орчныг мэдэрч өсөн торниж улмаар хэл яриа, зан харьцааны төлөвшлийг эцэг

эх, эмээ өвөө ойр орчны хүмүүсээсээ олж авна.

Гэр бүл дэх оюуны болон харилцааны соёлд гэр бүлийн хүрээнээс гадна цэцэрлэг, сургуулийн орчин багш, найз нөхөд, хөрш болон телевиз, радио, сонин сэтгүүл зэрэг ХМХ чухал үүргийг гүйцэтгэж байдаг.

Хорь гаруй жилийн өмнө монголчууд бид үндэсний ганц суваг, орбитын нэг сувгийг хар цагаан өнгийн телевизээр долоо хоногт 3-4 удаа цөөн хэдэн цагаар хүлээн авч үздэг байсан бол өнөөдөр бидний хэрэгцээ, нөхцөл боломж асар ихээр, хэд дахин нэмэгдэж хэн юу хүссэнээ, дурын сувгийг сонгон үзэх бүрэн бололцоотой болсон байна.

Дэлхийн техникийн асар хурдацтай хөгжлийн хамт хөл нийлүүлэн алхаж буй өнөөгийн нийгэмд манай улсын иргэд телевизийг бүрэн эзэмшиж, амьдралынхаа нэгэн чухал хэрэгцээ болгосон.

Та бид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж, өөрсдийн танин мэдэхүйн болон мэдээ мэдээллийг цаг алдалгүй өдөрт нь олон сувгаар хүлээн авч, улс оронд болж буй үйл явдлын талаархи мэдээ мэдээлэл, спорт урлагийн тоглолт, амьдрал ахуй, мэдлэг боловсрол, бизнест хэрэгтэй зар сурталчилгааг өдрөөс өдөрт хүлээн авсаар байна.

Өнөөдөр манай телевизүүд мэдээлэгч, танин мэдүүлэгч, зугаацуулагчийн үүргийг голлоод бусад удирдлагын хэрэгсэл, зохион байгуулагч, харилцааны

гээд гэр бүлийн соёлд чухал нөлөөлөх үүргүүдээ орхигдуулаад байна. Гэр бүл дэх оюуны болон харилцааны соёлд нөлөөлөх телевизийн нэвтрүүлгийг зохицуулан, нийгмийн санаа бодолд тулгуурлаж чадахгүй байна. Энэ нь сэтгүүл зүйн үүргээ биелүүлэхгүйгээс гадна олон нийтэд хандах зөв хандлага, дүрэм журам, хэм хэмжээ болох сэтгүүл зүйн зарчмаа мөн л бүрэн дүүрэн баримталж чадахгүй байгааг харуулж байна.

Жич: Зугаацуулах үүрэг нь бие хүн болон гэр бүлийн ямар ч гишүүнийг бүх талаар нь өв тэгш хүмүүжүүлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, танин мэдэхүйн хүрээг өргөжүүлэх, гоо зүйн хүмүүжил олгох, хүүхэд залуучуудын бие даасан байдлыг хөгжүүлэхэд чиглэсэн байх ёстой.

Гэтэл өнөөдөр манай ихэнх телевиз нь зугаацуулагч үүргээ хөгжөөнт цэнгээнт нэвтрүүлэг, гадаадын хөгтэй явдлын хуулбар, бичлэг, хошин урлагийн тоглолт, гадаадын кино зэргээр ялангуяа солонгосын цуврал кино үзүүлэх байдлаар гүйцэтгэж байна. Эдгээр нь гэр бүлийн соёлд хэрхэн нөлөөлөх нь ойлгомжтой. Тухайн үед хэсэгхэн зуур инээлгээд л өнгөрнө, эсвэл солонгосын

цуврал киног үзэж сурч боловсрох бүтээлч цагаа дэмий өнгөрөөнө.

Телевизийн олон арван сувгийн ач гавъяагаар бага дунд, өсвөр насны хүүхдүүд эцэг эх, хамт олноос олж аваагүй зарим мэдлэг, буруу үг хэллэгийг сурдаг. Тухайлбал,

А/ Эцэг эхийн хараа хяналт сул хүүхдүүдийн ихэнх хувь нь өөрийн хүссэнээр, дураараа байх дуртай байдаг. Гэртээ эмээ өвөө, ах дүүтэйгээ үлддэг эрх дураараа аашилдаг хүүхдүүд хэнээс ч үл хамааран видео сувгуудын гэмт хэрэг зодоонтой, садар самууныг сурталчилсан кино, аймшгийн кино зэргийг үзэж

«

*Цэцэрлэг, сургуулиар хүмүүждэг, эцэг эхтэйгээ ойр, тэдний үгийг хүлээн авдаг, халуун дулаан уур амьсгалтай гэр бүлд амьдарч байгаа хүүхдүүд эцэг эхийн хэлж зааснаар сөрөг нөлөөтэй кино сувгуудыг огт үздэггүй байна. Харин рекламн үг хэллэгийг дагаж цээжлэх, клип дуу хөгжмийг дуулж, сурах жишээтэй байдаг нь бодит амьдрал дээр нотлогдсон.*

»

утга санааг нь ойлгоогүй мөртлөө муу муухай үг хэллэг, гудамжны хар ярианы соёлгүй үг, хараалыг сурч улмаар амьдралдаа хэрэгжүүлж дууриаж эхэлдэг. Энэ үг хэллэг нь орчуулагчийн ур чадварыг ч давхар илтгэн харуулж байгаа юм.

Б/ Цэцэрлэг, сургуулиар хүмүүждэг эцэг эхтэйгээ ойр, тэдний үг хэлийг хүлээн авдаг халуун дулаан уур амьсгалтай гэр бүлд амьдарч байгаа хүүхдүүд эцэг эхийн хэлж зааснаар дээрх сөрөг нөлөөтэй кино сувгуудыг огт үздэггүй байна. Харин тэдний телевизээс хүлээн

авах мэдээлэл нь рекламн үг хэллэгийг дагаж цээжлэх, клип дуу хөгжмийг дуулж, сурах жишээтэй байдаг нь бодит амьдрал дээр нотлогдсон. Эцэг эхчүүд аль болох хүүхдүүдэд сайнаар нөлөөлөх, тэдний сонирхсон нэвтрүүлгийг хамт үзэж, зарим үед өөрсдийн үзэх сонирхолтой зүйлээс татгалзаж хүүхдийнхээ эрх ашигт нийцсэн кино, нэвтрүүлгийг үзэх нь чухал. Энэ байдалтай эвлэрч, дагаж чадвал гэр бүл дэх соёлын харилцаа хүүхдийн чинь хүмүүжилд ихээхэн ач холбогдолтой байх болно. Гэвч өнөөдөр бидний ирээдүй болсон хүүхдүүд маань тэр болгон гэр бүлийн хүрээнд хайр халамжийг хүлээн авч, соёл боловсролыг эзэмшиж, эдлэх ёстой эрхээ бүрэн эдэлж чадахгүй байна.

**Н**эг хэсэг нь телевизээс өөрийн амьдралд нөлөөлөх зүйлийг олж, харж мэдрэхгүй, тэр ч бүү хэл үзэж харах телевизгүй гэр бүл, орчинд амьдарч байна. Тийм гэр бүлийн соёлд үнэхээр телевизийн гүйцэтгэх үүрэг гэсэн ойлголт байхгүй, энэ үг тэдэнд огт хамааралгүй болж байгаа юм.

Тоотой хэдэн телевизээр гардаг цөөн тооны хүүхдийн нэвтрүүлгийг эс тооцвол ("Цоглог", "Унагалдайн мухлаг" г. м.) цэцэрлэгийн насны балчир хүүхэд болон сургуулийн бага, дунд ахлах насны хүүхдүүдэд зориулсан, тэдний сэтгэхүйд нийцсэн, мэдлэг олгох телевизийн нэвтрүүлгүүд бусад орныхтой харьцуулбал үнэхээр хомс байна.

Гэр бүл дэх оюуны болон харилцааны соёлд телевизийн гүйцэтгэж буй үүргийг тодорхойлохоор 17-75 насны оюутан, хуульч, сэтгүүлч, багш, орчуулагч, зураач, цэвэрлэгч, жижүүр, философич, бизнес эрхлэгч, эдийн засагч, эрдэмтэн доктор болон тэтгэврийн хөгшчүүл хамрагдсан нийт 300 гаруй хүнийг хамруулсан судалгаа хийж үзэхэд:

- Гэр бүл дэх оюуны болон харилцааны соёлд нөлөөлөх телевизийн нөлөөллийг нийт оролцогчдын 80 хувь нь нэлээд их, 10 гаруйхан хувь нь нөлөө байхгүй,

- Хүүхдийн хүмүүжилд болон танин мэдэхүйд гүйцэтгэх үүргийг нийт оролцогчдын 70 хувь нь чухал гэж үзсэн байхад дөнгөж 5 хувь нь л чухал бус,

- Цэнхэр дэлгэц үзэгчдийн ихэнх нь (70 гаруй хувь нь) мэдээ мэдээлэл, уран сайхны кино болон танин мэдэхүйн нэвтрүүлэг, хөгжмийн программыг илүү сонирхон үздэг

- MNB, ТВ-5, ТВ-9, UBS, MN-25-р суваг телевизүүд олон төрлийн нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлдэг, хөгжөөнт болон залуучуудын сонирхлыг татсан хөгжим, кино, спортын нэвтрүүлэгтэй, харин Eagle телевиз нь мэдээ мэдээлэл сайн хүргэдэг гэж хариулсан байна.

- Гэр бүл дэх оюуны болон харилцааны соёлд нөлөөлөх телевизийн эерэг ба сөрөг үзэгдлүүдийг дурдсан байдлыг авч үзвэл зарим хүмүүс телевизийг гэр бүлийн соёлд нөлөөлөх эерэг болоод

сөрөг талын аль аль нь адилхан 50, 50 хувьтай нөлөөлдөг гэж үзсэн байхад ихэнх хүмүүс нөлөөлөх сайн тал нь 70 хувь, муу тал нь 30 хувьтай гэж үзсэн байна. Хариулсан байдлыг нэгтгэн дүгнэхэд: ээрэг тал: мэдээ мэдээлэл цагт нь авдаг, цагийг үр ашигтай өнгөрүүлдэг, амралтаа зөв боловсон өнгөрүүлдэг, зугаатай, хөгжилтэй, сурч мэдэх, ухамсарлах, зарим нэвтрүүлэг юм бодогдуулдаг, зарим кино нь ухаарч ойлгуулах нөлөөтэй, олон нийтжих сайн талтай, гадаад дотоодын олон сувгаас сонгож үзэх, мэдээллийг олон сувгаар авах, танин мэдэхүйд ашигтай, сонирхолтой гэсэн байхад, сөрөг тал: суваг булаалдах, хүүхэд хичээл хийхэд саадтай, нэвтрүүлэг их давтагддаг, мэдээллийн хөтөлбөрөөр нэг загварт оруулсан юм шиг ижил, давтагдсан мэдээнүүдийг хүргэдэг, ард түмнийхээ амьдралын гүнд орж чаддагүй, хэвлэлийн олон бага хурлын мэдээллийг хүргэдэг, хэтэрхий улс төржсөн мэдээлэл өгдгөөс гэр бүлд маргааныг бий болгох сэжүүр болдог, нүдний хараа, эрүүл мэндэнд сөрөг нөлөөтэй, ялангуяа сүүлийн үед шинээр нэвтэрч буй ТВ-чаат нэвтрүүлэг, нэг кино үзээд суучихвал цаг их алддаг, зарим нэвтрүүлэг, садар самуун, алаан хядаан, аймшгийн кино нь хүүхдийн сэтгэхүй, гэр бүлийн соёл хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх муу талтай гэж судалгаанд оролцсон иргэд хариулсан байна.

Дээрх судалгаа гэр бүлийн орчин, оюуны болон харилцааны соёлд телевизийн гүйцэтгэж буй үүрэг өнөөдөр өндөр түвшинд байгааг илтгэж байна.

Телевиз нь тухайн телевизийн нэвтрүүлгийг үзэж буй ямар ч насны хүний сэтгэхүйд (ярилцлага, мэдээлэл, кино зэрэгт гарч буй хүний хэлсэн үг, хийсэн үйлдэл зэргээр) шууд нөлөөлдөг.

**Г**эр бүлийн таагүй орчин эцэстээ гэмт хэрэгтэнг төрүүлдэг гэж гэр бүл судлаачид дүгнэсэн байдаг. Гэвч таагүй орчныг бүрдүүлэгч эх үүсвэр нь юунд байна вэ? гэдэг нь чухал. Үүнд нөлөөлөх дотоод хүчин зүйлс нь:

*1. Гэр бүлийн харилцаа:*

- хэрүүл зодоонтой гэр бүл
- архичин эцэг эхийн нөлөө
- хойд эцэг эхийн дарамт,
- амьдрах орчны нөлөө
- эдийн засгийн нөөц бололцоо

*2. Мэдээллийн хэрэгслийн нөлөөлөл:*

- гэмт хэргийн талаархи хэт дэлгэрэнгүй мэдээлэл
- амрах зугаацах, цэнгэх, хөгжин баясах, бусдын хэрэгт дурлах зэрэгт түлхүү анхаарсан нэвтрүүлэг
- хэт бизнес хөөсөн арилжааны (зар сурталчилгааны мэдээ мэдээлэл, нэвтрүүлэг)
- ил тод, ёс бус секс үйлдэлтэй кино
- мөнгө хөөсөн мафийн үзэл сурталтай кино
- хэрүүл маргаан, өш хонзонтой кино г. м.

**Х**үүхдийн үйлдэж буй гэмт хэргийн зонхилох хувийг иргэдийн өмчийн хулгай, хүчин, дээрэм, танхайн гэмт хэрэг эзэлдэг байна. Энэ бүхэн нь эцэг эхийн бус зөвхөн бусдыг даган дууриах, тодруулбал ухуулах хичээл, сурталчилгаа биш ч телевизээр гарч буй киноны нөлөө юм. Гэр бүлийн гишүүд, хүүхдүүд ухамсаргүй үйлдлийн эцэст тэр бүгдийг хийж байж санаа нь амарч, эцэст нь хор хохиролыг нь амсдаг байна.

Буруу үзэгдлийн тусгал нь хүүхэд залуучуудад сөргөөр нөлөөлөхөд маш хялбар байдаг ч сайн зүйлс нь үлгэр дууриалал болон давтагддаг.

Иймээс гэр бүл дэх оюуны болон харилцааны соёлд телевизийн гүйцэтгэх үүрэг нэлээд чухал байгаа өнөө үед хүн амын төвлөрөл ихтэй хотод нэвтрүүлгээ цацаж буй телевизүүд өөрийн нэвтрүүлгийн бодлогод өөрчлөлт хийх цаг болжээ.

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. *Тунгалаг Д.* 2005. Гэр бүлийн ёс суртахуун. УБ.

2. *Зулькафиль М., Чойсамба Ч.* 2001. Чөлөөт хэвлэл: өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ.

3. 2001. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө. "Глоб интернейшнл" ТББ. УБ.

4. *Жаргал С.* 2004. Нийтийн соёл ба Монголын Үндэсний телевиз. УБ.

5. *Намжил Т.* 2005. Гэр бүл: орчин үеийн асуудлууд. УБ.

6. *Төмөрбаатар Ж., Төмөрхуяг Н.* 2001. Соёл судлалын үндэс. УБ.

#### **Резюме**

На основе социологического опроса аудитории автор в данной статье рассматривает роль СМИ, в том числе телепередач в духовной и коммуникационной культуре современной монгольской семьи. Благодаря социальному и техническому развитию монгольские телезрители сегодня получают информации на любой вкус по разным каналам. Но аудитория считает, что качество и результат этих информационных сообщений не соответствуют её требованию. Автор считает, кроме родителей в образовании и воспитании детей сильное влияние оказывает телепередачи и кино.